



ТАВАНТОЛГОЙ ХК
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 34

Өмнөговь аймаг

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Тавантолгой” ХК-ийн 2022 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг болгон нэгж хувьцаанд 2743.8 / хоёр мянга долоон зуун дөчин гурван төгрөг наян мөнгө/ төгрөгөөр хуваарилахаар тогтоосугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Тогтоолын 1, 2-д заасан ногдол ашгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хувьцаа эзэмшигчдэд 2023 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн мөнгөн хэлбэрээр тараасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг ханган холбогдох гэрээ хэлцэл байгуулах, төлбөр тооцоо хийх, тайлан мэдээг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж ажиллахыг Гүйцэтгэх удирдлага, Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч /П.Сайнзориг/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ТҮВШИНБАЯР